# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2023 оны 09 сарын 26 өдөр Дугаар 357 Улаанбаатар хот

## Ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Олон улсын гэрээний тухай хуулийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 3.1.1.1 дэх заалт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс 2021 онд болсон 50 дугаар чуулганы үеэр гаргасан зөвлөмжүүдийг 2023-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг хавсралт ёсоор батлсугай.

2.Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, хангах, төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Гадаад харилцааны яаманд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт даалгаж, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисст тус тус зөвлөсүгэй.

3.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт даалгасугай:

3.1.Холбогдох яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, албан тушаалтан, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулж ажиллуулах;

3.2.Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан энэ тогтоолын 3.1-д заасан орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлж, хэрэгжилтийн тайланг, цаашид авах арга хэмжээний саналын хамт тухайн жилийн 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулах;

3.3.Ерөнхий төлөвлөгөөний дунд хугацааны хэрэгжилтийн тайланг бэлтгэж, 2024 оны 2 дугаар сард багтаан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлд хүргүүлэх;

3.4.Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний дөрөвдүгээр илтгэлийг ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд тулгуурлан иргэний нийгмийн байгууллага болон холбогдох бусад байгууллагатай зөвшилцөн 2025 оны 6 дугаар сард багтаан боловсруулж, Засгийн газарт танилцуулах.

4.Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, уг үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгт тус тус үүрэг болгосугай.

5.Ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр улс болон орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний комисст тус тус зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Б.БАТЦЭЦЭГ

Засгийн газрын 2023 оны 09 дүгээр
сарын 26-ны өдрийн 357 дугаар
тогтоолын хавсралт

# НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ 2023-2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зөвлөмж/зөвлөмжийн дугаар | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хариуцан хэрэгжүүлэх байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|---|---|
| Нэг. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр | | | | | |
| 1. | 116.3.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох (Казахстан), Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний үр дүнтэй механизмыг хойшлуулшгүйгээр бий болгох (Украин) | -Мөрдөх албаны тухай хуулийн төсөл боловсруулах,<br><br>-Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, хараат бусаар мөрдөн шалгах бие даасан нэгжийг байгуулах, бүтэц, орон тоо, төсвийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах,<br><br>-Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор төв, орон нутгийн цагдаагийн байгууллага бүрд зориулалтын дуу, дүрс бичлэгийн болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглосон байцаалтын өрөөг нэмэгдүүлэх,<br><br>-Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар мөрдөгч, прокурор, эрх бүхий байгууллагын албан тушаалтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах, | -Хуулийн төсөл боловсруулан УИХ-д өргөн мэдүүлсэн байна.<br><br>-Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах механизмыг байгуулсан байна.<br><br>-Байцаалтын өрөөг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.<br><br>-Сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулсан байна.<br><br>-Видео мэдээлэл, зурагт хуудас гаргаж, түгээсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар. | Улсын ерөнхий прокурорын газар,<br><br>Тагнуулын ерөнхий газар,<br><br>Авлигатай тэмцэх газар,<br><br>Хүний эрхийн үндэсний комисс,<br><br>Хууль зүйн туслалцааны төв. |
| 2. | 116.4.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд заасны дагуу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизм бий болгох үйл явцыг хурдасгах, эрүү шүүлт, тэр дундаа эрх чөлөөг нь хассан хүнийг эрүүдэн шүүсэнтэй холбоотой гомдлыг шалган шийдвэрлэх бие даасан, үр дүнтэй | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | процедур бий болгох (Мексик) | | | | |
| 3. | 116.49.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцсан тухай гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх үр дүнтэй механизм бий болгох (Франц) | -Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар видео мэдээлэл, зурагт хуудас бэлтгэн олон нийтэд хүргэх,<br><br>-Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн судалж дүгнэх, шалтгаан нөхцөлийг тогтоож, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах. | -Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. | | |
| 4. | 116.51.Эрүүдэн шүүх, хүний нэр төрийг гутаан доромжилсон хэргийг мөрдөн шалгах бие даасан байгууллага байгуулах (Мальдив) | | | | |
| 5. | 116.53.Эрүүдэн шүүхтэй тэмцэх чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх, ингэхдээ хууль тогтоомжийн хүрээнд гомдол хянан шийдвэрлэх бие даасан механизм бий болгох, эрүү шүүлтийн талаарх гомдлыг хараат бусаар, шуурхай мөрдөн шалгах нөхцөлийг бүрдүүлэх (Румын) | | | | |
| 6. | 116.54.Эрүү шүүлтийн хэргийг мөрдөн шалгах бие даасан, үр дүнтэй гомдлын механизм бий болгох (Испани) | | | | |
| 7. | 116.55.Эрүү шүүлтийн талаар гомдол гаргах, гомдлыг мөрдөн шалгах механизмыг бэхжүүлж, үр дүнтэй байдлыг хангах (Ботсвана) | | | | |
| 8. | 116.52.Хоригдсон хүмүүстэй зүй бус харьцсан тухай гомдол мэдээллийг мөрдөн шалгах хүч чармайлтаа сайжруулах (Польш) | -Хорих анги, цагдан хорих, баривчлах, саатуулах байранд хоригдогчид эрүү шүүлт тулгах, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус харьцсан эсэхийг шалгаж, холбогдох арга хэмжээ авах. | -Шалгалт зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гарган хэрэгжүүлсэн байна. | Улсын ерөнхий прокурорын газар. | |
| 9. | 116.50.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа шүүгч, прокурор болон албан хаагчдад зориулан сургалт тогтмол явуулах замаар урьдчилан сэргийлэх арга хэмжээг бэхжүүлэх (Индонез) | -Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаар сургалтын агуулга боловсруулж, шүүгч, прокурор, мөрдөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан болон хуульчдад сургалт тогтмол зохион байгуулах. | -Сургалтын агуулга боловсруулж, сургалт зохион байгуулсан байна. | Шүүхийн ерөнхий зөвлөл,<br><br>Улсын ерөнхий прокурорын газар,<br><br>Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Тагнуулын ерөнхий газар, | Хүний эрхийн үндэсний комисс,<br><br>Монголын хуульчдын холбоо. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Авлигатай тэмцэх газар,<br><br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. | |
| 10. | 116.56.Хорих ангийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, хүний эрх чөлөөг хязгаарладаг бүхий л газарт хараат бусаар тогтмол хийх хяналт шалгалтыг бэхжүүлэх (Норвеги) | -Хорих ангид нийгмийн амьдралын хэв шинжийг агуулсан, сургалт зохион байгуулах боломж бүхий, аюулгүй байдлын шаардлага хангасан “Суллагдахад бэлтгэх байр”-ны шаардлагатай төсвийг үе шаттайгаар шийдвэрлүүлэх. | -Шаардлагатай төсвийг үе шаттайгаар шийдвэрлэсэн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. | |
| 11. | 116.57.Хорих ангийн хэт ачааллыг бууруулах чиглэлээр арга хэмжээ үргэлжлүүлэн авах (ОХУ) | -Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг хүний эрхийг хангасан түвшинд хүргэх, насанд хүрээгүй хоригдлын сурч боловсрох эрхийг хангах зорилгоор сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын цогцолбор барилга, байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулах,<br><br>-Орон нутаг дахь цагдан хорих байрыг үе шаттайгаар шинэчлэх, олон улсын стандартад нийцсэн цагдан хорих, баривчлах байрыг шинээр барьж ашиглалтад оруулах. | -Шаардлагатай төсвийг үе шаттайгаар шийдвэрлэсэн байна.<br><br>-Баян-Өлгий, Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байрыг шинээр барихад шаардлагатай төсвийг үе шаттайгаар шийдвэрлэсэн байна. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар. | Аймаг, нийслэлийн Засаг дарга. |
| Хоёр.Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр | | | | | |
| 12. | 116.16.Эмзэг бүлгийн хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Кувейт) | -Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хүүхдийн оролцооны талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох, эрх зүйн үндсийг бүрдүүлэх, | -Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авсан байна.<br><br>-Ахмад настан, | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Барилга, хот байгуулалтын яам. | Боловсрол, шинжлэх ухааны яам,<br><br>Бүх шатны Засаг дарга. |
| 13. | 116.17.Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан зэрэг эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | сонирхлыг хамгаалах үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Лаос) | -Ахмад настны тухай хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд тусгах,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх,<br><br>-Ахмад настны эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтэд насжилтын талаар эерэг хандлага, зан байдлыг бий болгох, ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах нөлөөллийн арга хэмжээ тогтмол зохион байгуулах,<br><br>-Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг батлуулах, хуулийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулах,<br><br>-Орон нутагт мэргэжлийн дохионы багш, мэргэжилтэн бэлтгэх ажлыг зохион байгуулах,<br><br>-Хүүхдийн тоглоомын талбайн Монгол Улсын стандарт MNS6751:2019 хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ авах. | олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.<br><br>-Саадгүй байдал хүртээмжийн тухай хуулийн төсөл, холбогдон гарах журмын төсөл боловсруулан батлуулахаар зохих арга хэмжээ авсан байна.<br><br>-Орон нутагт дохионы багш бэлтгэсэн байна.<br><br>-Хүүхдийн тоглоомын талбайд шалгалт явуулж, стандартад нийцүүлэн шинэчилсэн байна. | | |
| 14. | 116.18.Эмзэг бүлгийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Ливан) | | | | |
| 15. | 116.141.Хүүхдийн эрх хамгааллыг бэхжүүлэхэд чиглэсэн хүч чармайлтыг бүх түвшинд үргэлжлүүлэх (Ливан) | | | | |
| 16. | 116.144.Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээрх хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Вьетнам) | | | | |
| 17. | 116.19.Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан зэрэг нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хууль тогтоомжоор болон практикт үргэлжлүүлэн хамгаалах (ОХУ) | | | | |
| 18. | 116.115.Эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд илүү хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлж, тэдний эдийн засгийн салбарт өрсөлдөх явдлыг хөхиүлэн дэмжиж, эмэгтэйчүүдийн эсрэг хөдөлмөрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох арга хэмжээ авах (Энэтхэг) | -Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (бүлгийн зохион байгуулалттайгаар өртгийн сүлжээ бий болгох) арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх. | -Арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | |
| 19. | 116.117.Эмэгтэйчүүдийг эдийн засгийн хувьд бие даахад нь туслах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр хүч чармайлтаа эрчимжүүлэх, үүнд мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх ажил зохион байгуулах, мэргэжлийн болон техникийн | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | сургалт явуулах (Монтенегро) | | | | |
| 20. | 116.118.Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг арилгах үүднээс охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн боловсрол хийгээд эдийн засгийн нөхцөл бололцоог дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж бэхжүүлэх (Филиппин) | -Охид, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг арилгах үүднээс Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах. | -Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<br><br>-Мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. |
| 21. | 116.151.НҮБ-ын Хүүхдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээний тухай удирдамж болон Ерөнхий тайлбар №6-г харгалзан үзэж хувилбарт үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд чанартай халамж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийг дэмжих үйлчилгээг бий болгож, сайжруулах, нийгмийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулж чанартай сургалт зохион байгуулах, хүүхэд эцэг эхээсээ шаардлагагүйгээр хагацахаас урьдчилан сэргийлэх (Словени) | -Гэр бүлийг дэмжих үйлчилгээг бий болгож, нэвтрүүлэх,<br><br>-Хүүхэд харах хувилбарт үйлчилгээг хэрэгжүүлж, хүүхдийг Асралт гэр бүлд асран хамгаалах, гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх. | -Холбогдох стандарт, журмыг боловсруулсан байна.<br><br>-Хүүхэд харах хувилбарт үйлчилгээг нэвтрүүлж, гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Эрүүл мэндийн яам,<br><br>Боловсрол, шинжлэх ухааны яам. |
| 22. | 116.116.Эмэгтэйчүүдийг санхүүгийн хувьд бие даахад нь туслах таатай орчин бүрдүүлэх чиглэлээр хүч чармайлтаа эрчимжүүлэх, ялангуяа ажлын байранд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглох талаар төрийн албан хаагчид болон хувийн хэвшлийн ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх (Люксембург) | -Төрийн албан хаагчдын жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх,<br><br>-Жендэрийн сургагч багш, шинжээч бэлтгэх,<br><br>-Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах,<br><br>-"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031 он)"-ний хэрэгжилтийг хангах. | -Сургалтад удирдах албанд 75 хувь, төрийн албан хаагч 85 хувь хамрагдсан байна.<br><br>-400 сургагч багш, шинжээч бэлтгэсэн байна.<br><br>-Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 75 хувь хангагдсан байна.<br><br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба. | Жендэрийн бүх салбар зөвлөл, хороод. |
| 23. | 116.119.Нийгэмд жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих чиглэлээр нэмэлт арга хэмжээ авах, түүний дотор 2011 онд батлагдсан Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг түргэтгэх (Япон) | | | | |
| 24. | 116.120.Жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжихэд салбар хоорондын болон төрийн байгууллага хоорондын | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хамтын ажиллагааг үргэлжлүүлж, ажлын байран дахь жендэрийн саад тотгор, өрөөсгөл ойлголтыг даван туулах практик арга хэрэгслээр дамжуулан эмэгтэйчүүдийг чадавхжуулах сургалтын хөтөлбөр боловсруулахад олон улсын холбогдох түншүүдтэй хамтран ажиллах (Сингапур) | | | | |
| 25. | 116.161.Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Гүрж) | -Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулах, хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг нарийвчлан тусгах,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг боловсронгуй болгох,<br><br>-Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлэх. | -Холбогдох хуулийн төслийг батлуулсан байна.<br><br>-Арга хэмжээг боловсронгүй болгосон байна.<br><br>-Төсөл хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Эрүүл мэндийн яам. |
| 26. | 116.162.Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг албадан эмчлэх, гутаан доромжлох, хүчирхийлэл үйлдэх, дарамт шахалт үзүүлэх, хэт их эмчилгээ хийхтэй тэмцэх, тэднийг нийгэмд нэгдэн амьдрахыг нь дэмжиж сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга замаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын дагуу сэтгэцийн болон нийгмийн сэтгэцийн эмгэгтэй хүмүүст дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн ээлтэй, халамжийн хувилбарт үйлчилгээ бий болгох, тэдгээр хүмүүсийн шийдвэрээ мэдээллийн үндсэн дээр, чөлөөтэй гаргах эрхийг нь хүндэтгэн хангах (Португал) | | | | |
| 27. | 116.163.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, тэгш бус байдалтай тэмцэх стратеги боловсруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай зөвлөлдөх албан ёсны, байнгын механизм бий болгох (Испани) | -Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, салбар бүрд хөгжлийн бэрхшээлтэй хүнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах. | -Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан байна.<br><br>-Зөвлөлийн төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 28. | 116.164.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах (Сири) | -Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээ болон салбарын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг газруудад хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ бүхий тусгай цонх бий болгох, нэгдсэн үйлчилгээгүй газруудад дугаар харгалзахгүй үйлчлэх нөхцөл бололцоогоор хангах. | -Тэмдэг, тэмдэглэгээ байршуулан, холбогдох дүрэм журмыг баталж мөрдүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. |
| 29. | 116.165.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангах чиглэлээр амжилттай хэрэгжүүлж буй үндэсний бодлогыг үргэлжлүүлэх (Венесуэл) | | | | |
| 30. | 116.166.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд, хөвгүүдийн эрхийг хангахад чиглэсэн хүч чармайлтыг нэмэгдүүлэх (Аргентин) | -Олон улсын байгууллагатай хамтран "тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн 2 дахь үе шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. | -Төсөл хэрэгжүүлсэн байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. |
| 31. | 116.168.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн амьдралд оролцох нөхцөлийг баталгаажуулах, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хөндөж буй шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Норвеги) | -Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссын үйл ажиллагааг сайжруулах. | -Төсөл хэрэгжүүлсэн байна.<br><br>-Комиссын үйл ажиллагааг эрчимжүүлж, төлөвлөгөө баталж хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | |
| 32. | 116.169.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц хөгжлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Оман) | | | | |
| 33. | 116.170.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмээс тусгаарлахгүй байх нөхцөлийг баталгаажуулах чиглэлээр нэмэлт арга хэмжээ авах (Тимор-Лесте) | | | | |
| | Гурав.Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр | | | | |
| 34. | 138.Шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (Иран) | -Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хийсэн 2021 оны үнэлгээнд үндэслэн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах,<br><br>-Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, | -Холбогдох арга хэмжээ авсан байна.<br><br>-Жендэрийн талаар олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион | Жендерийн үндэсний хорооны Ажлын алба,<br><br>Аймаг, нийслэлийн Засаг дарга. | Хууль зүй, дотоод хэргийн яам. |
| 35. | 140.Улс төрийн болон бусад холбогдох шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хүч чармайлтыг үргэлжлүүлэх (Балба) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 36. | 139. Жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрөөр дамжуулан шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Лаос) | -Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулах гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгайлан заалт оруулж, үр дүнг дүгнэх. | байгуулсан байна.<br><br>-Үр дүнгийн гэрээнд тусгаж, хэрэгжилтийг дүгнэсэн байна. | | |
| Дөрөв.Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр | | | | | |
| 37. | 116.10.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Израиль) | -Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т заасны дагуу Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх,<br><br>-Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох криминологи, виктимологийн судалгаа хийх, холбогдох арга хэмжээ авах,<br><br>-Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж, иргэд, олон нийтэд сурталчлан танилцуулах. | -Үр дагаврын үнэлгээний тайланг холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж, тодорхой шийдвэр гарсан байна.<br><br>-Судалгааны үр дүнд суурилсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.<br><br>-Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн хохирсон талаарх болон бусад мэдээлэл хамгаалагдсан байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн ажлын алба. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Улсын ерөнхий прокурорын газар,<br><br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,<br><br>Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Төрийн бус байгууллага,<br><br>Хууль зүйн туслалцааны төв. |
| 38. | 116.124. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн дарамттай тэмцэхэд чиглэсэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх (Итали) | | | | |
| 39. | 116.127. Охид, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Энэтхэг) | | | | |
| 40. | 116.136.Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Балба) | | | | |
| 41. | 116.130.Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүч чармайлтаа үргэлжлүүлэх, ялангуяа хууль сахиулах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, хөрөнгө хуваарилах, түүнчлэн хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүсийн хамгаалалт болон үйлчилгээ авах нөхцөл боломжийг сайжруулах (Канад) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 42. | 116.131.Бэлгийн дарамтад өртсөн хохирогчдын хувийн нууцыг хамгаалах хууль, эрх зүйн орчин бий болгож, хохирогчдыг нөхөн сэргээх зорилгоор аюулгүй орон байраар хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх (Эстони) | | | | |
| 43. | 116.133.Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх (Филиппин) | | | | |
| 44. | 116.135.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бүх хохирогчийг хамгаалах чиглэлээрх үндэсний механизмуудыг улам бүр бэхжүүлэх (Киргиз) | | | | |
| 45. | 116.134.Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, парламент болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог улам бүр нэмэгдүүлэх чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (БНСУ) | | | | |
| 46. | 116.11.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцаж байгаа албан хаагчдыг сургалтад хамруулах, зохих нөөц хуваарилах замаар хуулийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарах (Перу) | -Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хамтарсан багийн гишүүдийг сургах, давтан сургах, ажлын байранд чадавхжуулах,<br><br>-Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг мэргэшүүлэх, үйлчилгээний онцлог тус бүрээр дадлагажуулан чадавхжуулах,<br><br>-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу хууль сахиулагчийг бэлтгэдэг дотоодын их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүчирхийллийн аюул заналхийллийг үр дүнтэй үнэлэх, гэр бүлийн хүчирхийлэл | -Хамтарсан багийн 3000-аас доошгүй гишүүдийг сургасан байна.<br><br>-Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн 100-аас доошгүй ажилтныг сургасан байна.<br><br>-Сургалтын хөтөлбөрт холбогдох агуулгыг тусгаж, хэрэгжүүлсэн | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Эрүүл мэндийн яам,<br><br>Боловсрол, шинжлэх ухааны яам. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба,<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар, |
| 47. | 116.129.Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ авах, үүний дотор цагдаагийн алба хаагчдыг хохирогч тэвтэй аюул заналхийллийн үнэлгээг хэрхэн үр дүнтэй хийх талаар сургаж дадлагажуулах (Дани) | | | | |
| 48. | 116.132.Гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх тусламж, | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээний талаарх хууль сахиулах байгууллагын ажилтнууд, хуульчид, шүүгчдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах (Фижи) | болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээний талаарх агуулгыг тусгах,<br><br>-Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгч нартай ажилладаг цагдаагийн алба хаагч, хуульчдад хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчдэд сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх арга техникийн талаар сургалт зохион байгуулах. | байна.<br><br>-Сургалт зохион байгуулсан байна. | | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,<br><br>Дотоод хэргийн их сургууль,<br><br>Төрийн бус байгууллага. |
| 49. | 116.12.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, мэдээлэх чиг үүрэгтэй салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх (Австрали) | -Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх санхүүжилтийг гүйцэтгэлд суурилан төлөвлөж хуваарилах, нэмэгдүүлэх арга хэмжээ авах | -Санхүүжилтийг нэмэгдүүлж төсөвт тусгасан байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба,<br><br>Сангийн яам. | Бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга. |
| 50. | 116.123.Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрөөс хууль эрх зүйн хамгаалалт, үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн хүртээмжтэй байдал, олон нийтэд хүргэх чиглэлээр ахиц дэвшил гаргахыг үргэлжлүүлэх (Чили) | -Гэр бүлийн харилцаа, гэр бүлийн эрх зүй, гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээлэл, эрх зүйн болон сэтгэл зүйчийн зөвлөгөөг хүртээмжтэйгээр иргэд, олон нийтэд хүргэх. Энэ хүрээнд:<br>1)Гэр бүлд зориулсан мэдээлэл, зөвлөгөө, тусламжийн цахим платформ бий болгох, хөгжүүлэх, тогтвортой ажиллуулах;<br>2)Тусламж, зөвлөгөөний тусгай дугаарын утасны цэс, үйл ажиллагааг өргөжүүлэн, иргэд, олон нийтэд байнгын тогтвортой үйлчилгээ үзүүлэх;<br>3)Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 тусгай дугаарын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор тус дугаарын автомат хариулагчийн дуудлагын бүтцэд гэр бүлийн хүчирхийллийн талаар цэс нэмэх.<br><br>-Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, | -Мэдээ, мэдээлэл, тусламж, үйлчилгээний цахим хуудас, чатбот зэрэг 2-оос доошгүй платформ бий болж, зөвлөгөө, мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.<br><br>-Тусгай дугаарын утасны ажиллагаа өргөжиж, үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо 10-аас доошгүй хувь нэмэгдсэн байна.<br><br>-Эрх зүйн хөтөч фэйсбүүк хуудасны чатбот хэсгээр | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба,<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,<br><br>Төрийн бус байгууллага,<br><br>Хууль зүйн туслалцааны төв,<br><br>Хүүхдийн тусламжийн 108 утас. |
| 51. | 116.128.Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түгээмэл хэлбэр, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хүч чармайлтаа эрчимжүүлж, хохирогчдод зохих дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх (Чех) | | | | |
| 52. | 116.125Аливаа хэлбэрийн хүчирхийллийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд туслах арга хэмжээг бэхжүүлэх, үүнд хоргодох байр, хохирогчдод дэмжлэг, тусламж үзүүлэх үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх (Мьянмар) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 53. | 116.126.Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг бэхжүүлэх (Сенегал) | үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх,<br><br>-Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах чиг үүрэг бүхий нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд үйлчилгээний нэгдсэн стандартыг мөрдүүлэх,<br><br>-Хүчирхийллийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх иргэдийн зан үйл, хандлагыг өөрчлөх чиглэлээр соён гэгээрүүлэх үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах,<br><br>-Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой ажилладаг албан хаагчдын нийгмийн ажлын чадавхыг бэхжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах. | дамжуулан гэр бүлийн эрх зүй болон гэр бүлийн хүчирхийллийн талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэж ажилласан байна. | | |
| 54. | 116.137.Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгаалах байр, хохирогчдыг дэмжих үйлчилгээнд хамрагдах боломжийг өргөжүүлж, холбогдох ажилтнуудад тэдний онцлог хэрэгцээ, эмзэг байдлын талаар зохих сургалтыг зохион байгуулах (Бахам) | -Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамруулах зорилгоор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны тоог нэмэгдүүлэх,<br><br>-Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажилчдыг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх арга зүйд сургах | -Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй орчин бүхий хамгаалах байр 3-аас доошгүй байгуулсан байна.<br><br>-Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны 50-аас доошгүй ажилтныг жил бүр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх арга зүйд сургасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Бүх шатны Засаг дарга. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,<br><br>Төрийн бус байгууллага. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Тав.Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр | | | | |
| 55. | 116.109."Нэг Монгол" үндэсний нэлттэй боловсролын хөтөлбөрийг орчин үеийн боловсролын арга барил, интернет ашиглан насан туршийн боловсрол олгоход чиглэсэн шинэ технологиор баяжуулан бэхжүүлэх (Венесуэл) | -Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх. | -Боловсролын хөтөлбөр, агуулгыг цахим хэлбэрт шилжүүлэн хөгжүүлж эхэлсэн байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | |
| 56. | 116.108.2021–2030 оны Боловсролын салбарын мастер төлөвлөгөөг батлах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах (Киргиз) | -Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, боловсролын салбарын тогтолцоо, үйлчилгээний чанарыг сайжруулах, боловсролын үйлчилгээний хүртээмж, тэгш хамрах сургалтыг нэмэгдүүлэх. | -Дунд хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна. | | |
| 57. | 116.112.Боловсролын салбарын мастер төлөвлөгөөг шуурхай эцэслэж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахын тулд холбогдох талуудтай зөвшилцөн олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулах (Сингапур) | | | | |
| 58. | 116.110.Эмзэг бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулах замаар бүх түвшний хүүхдүүд боловсролд тэгш хамрагдах боломжийг баталгаажуулах чиглэлээр хүч чармайлтаа бэхжүүлэх (Мальдив) | -Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхэд боловсрол эзэмших, тэгш хамран сургах нөхцөлийг бүрдүүлэх,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх,<br><br>-Хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжих арга зүйн зөвлөмж боловсруулж түгээх, хүүхдийн ялгаатай хэрэгцээтэй сурагчдад зориулсан сургалтын хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, танхимын болон танхимын бус, эдгээрийн хосолсон хэлбэрээр зохион байгуулж хэрэгжүүлэх,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамран сургах эрх зүйн баримт бичгийг боловсруулах. | -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хамруулсан байна.<br><br>-Зөвлөмж боловсруулж түгээсэн байна.<br><br>-Сургалтын жишиг хөтөлбөр боловсруулсан байна.<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах талаар шийдвэр баталсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Төрийн бус байгууллага. |
| 59. | 116.167.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг (үүнд, алслагдмал бүс нутагт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших эрх багтана) хамгаалах, хөхиүлэн дэмжих, чиглэлээрх хүч чармайлтыг үргэлжлүүлэх (Япон) | | | | |
| 60. | 116.145.Бүх түвшний хүүхдүүд, түүний дотор алслагдмал нутаг дэвсгэрт амьдардаг болон амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах (Украин) | | | | |
| | | -Хүүхдийн төлөө зөвлөлийн чадавхыг | -Арга зүйн зөвлөмж | Хөдөлмөр, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бэхжүүлэх, арга зүйн зөвлөмж боловсруулж, түгээх,<br><br>-Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд 6 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв байгуулах. | боловсруулж, сургалт зохион байгуулсан байна.<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв байгуулсан байна. | нийгмийн хамгааллын яам. | |
| 61. | 116.146.Эмзэг, гадуурхагдсан бүлгийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, хүүхэд бүрд боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлэх (Афганистан) | -Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэр хороололд "Өргөө цэцэрлэг", "Хүрээ" бага сургууль байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлэх,<br><br>-Сургуульд шинээр элсэн суралцаж байгаа малчдын хүүхдэд зориулсан жишиг дотуур байр барих,<br><br>-Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөдөөгийн цэцэрлэг, сургууль, дотуур байрыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээ авах,<br><br>-Боловсролын байгууллагын барилга байгууламж, дотуур байр, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх шаардлагыг хууль тогтоомжид тусгах | -Гэр хороололд цэцэрлэг, сургуулийн тоог нэмсэн байна.<br><br>-Аймаг бүр хоёроос доошгүй жишиг дотуур байртай болсон байна.<br>-Хөдөө, орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байр нь ариун цэврийн байгууламж, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 62. | 116.111.Үндэстний болон хэлний цөөнх, түүнчлэн уугуул иргэдийн боловсролын хүртээмжийг үргэлжлүүлэн бэхжүүлэх (Перу) | -Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үзэл баримтлалыг боловсруулж, 2024 оноос сургалтын хөтөлбөрийг шинэчлэх бэлтгэлийг хангах,<br><br>-"Тува хэлний хөтөлбөр"-ийг тува хүүхдүүд оршин суудаг, сурдаг аймаг орон нутагт хичээлийн хөтөлбөрт оруулах, холбогдох сурах бичгийг хэвлэн гаргах | -Сургалтын хөтөлбөр шинэчилсэн байна.<br><br>-"Тува хэлний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | |
| 63. | 116.113.Хүртээмжтэй боловсролын ерөнхий бодлогыг боловсруулах болон боловсрол, ялангуяа дээд боловсрол эзэмших эрхээ эдлэхэд нь хүн бүрд тэгш боломж олгох чиглэлээрх хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Тунис) | -Оюутан төвтэй сургалтын үйл ажиллагааг дэмжсэн сургалтын орчинд тавих шаардлага боловсруулж, стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгох,<br><br>-Их сургуулиудыг бүсчилж хотхоноор хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх,<br><br>-Тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг (ахисан түвшний судлаач оюутан, тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн оюутан, тусгай хэрэгцээт, эмзэг бүлгийн суралцагч) үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх. | -Сургалтын орчны дэд бүтцийг байгуулсан байна.<br><br>-Бодлогын баримт бичиг баталсан байна.<br><br>-Их, дээд сургуульд суралцагч оюутнуудад тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. | | |
| 64. | 116.150.Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, түүний дотор гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүч чармайлтаа ахиулах (Итали) | -Холбогдох байгууллагын алба хаагчдыг сурган дадлагажуулах, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж, илрүүлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх,<br><br>-Нийслэл, аймаг, орон нутагт ажиллаж буй хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход сургуулийн орчинд эцэг, эхийн оролцоог дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулах, өсвөр үеийнхэнд чиглэсэн мэдээлэл, зөвлөгөөг тогтмол түгээх. | -Сургалт зохион байгуулсан байна.<br><br>-Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар. | Аймаг, нийслэлийн Засаг дарга. |
| 65. | 116.142.Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг | -Боловсролын тухай багц хуульд | -Боловсролын тухай | Боловсрол, | Цагдаагийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бэхжүүлэх чиглэлээр нэмэлт арга хэмжээ авах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших бүрэн боломжийг бүрдүүлэх, хүүхдүүдийг хөдөлмөрийн хортой нөхцөлд ажиллуулах явдлыг таслан зогсоох (Польш) | хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах тухай тусгах,<br><br>-Сургууль, багш нарт зориулсан арга зүйн зөвлөмж боловсруулж, түгээх,<br><br>-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах "Загвар төсөл"-ийг хэрэгжүүлэх,<br><br>-Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран "Star 2" боловсролын төслийг хэрэгжүүлэх,<br><br>-Эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд тохирсон боловсролын үйлчилгээ үзүүлэх. | багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.<br><br>-Арга зүйн зөвлөмж боловсруулж, түгээсэн байна.<br><br>-Загвар төсөл хэрэгжүүлсэн байна.<br><br>-"Star 2" төсөл хэрэгжүүлсэн байна.<br><br>-Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, эцэг эхийн оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлсэн байна. | шинжлэх ухааны яам. | ерөнхий газар,<br><br>Төрийн бус байгууллага,<br><br>Олон улсын байгууллага. |
| 66. | 116.143.Хүүхдийг кибер гэмт хэргээс хамгаалах зорилгоор мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх (Сири) | -Сурагчдын дунд цахим орчны зохистой хэрэглээний талаар уралдаан, мэтгэлцээн зэрэг арга хэмжээ зохион байгуулах,<br><br>-Цахим орчныг зохистой ашиглах, кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн сурагч, эцэг эхчүүдэд зориулсан мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх гарын авлага, материал бэлтгэх, түгээх, | -Уралдаан, мэтгэлцээн зохион байгуулсан байна.<br><br>-Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.<br><br>-Энэ чиглэлээр 50-аас доошгүй | Харилцаа холбооны зохицуулах хороо,<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Улсын ерөнхий прокурорын газар,<br><br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын |
| 67. | 116.157.Төрсний бүртгэлийг хүүхдийн хувийн байдал, насыг бүртгэх зориулалтынх нь хувьд боловсронгуй болгож, Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хөдөлмөрийн хяналт шалгалтын дэглэмийг сайжруулах замаар хүүхдийн хөдөлмөрийг | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | мөлжихөөс урьдчилан сэргийлэх засаглалын механизмыг бэхжүүлэх (Ботсвана) | -Сураггүй алга болсон болон мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд туслах олон улсын төв (ICMEC)-тэй хамтран хүүхдийг сураггүй алга болох, хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулах. | төрийн албан хаагчийг сургасан байна. | | хөгжлийн газар. |
| 68. | 116.147.Хүүхдийн эндэгдлийн түвшнийг улам бууруулах зорилгоор хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Иран) | -“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх,<br><br>-Хүүхдийн хорт хавдрын өнөөгийн нөхцөл байдал, шийдвэрлэх асуудалд дүн шинжилгээ хийх,<br><br>-Глобаль санаачилгад орсон 6 төслийн хавдрын үед үзүүлэх тусламж, үйлчилгээний эмнэл зүйн зааварт орсон эмийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх. | -Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.<br><br>-Дүн шинжилгээний тайлан, санал, зөвлөмжийг үндэслэн цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталсан байна.<br><br>-Хавдрын эмчилгээний эмийн хангамж, хүртээмж сайжирсан байна. | Эрүүл мэндийн яам. | Аймаг, нийслэлийн ЭМБ,<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. |
| 69. | 116.148.Хөдөө, орон нутгийн болон бага орлоготой өрхийн хүүхдүүдэд онцгой анхаарал хандуулж, хүүхэд бүр эрүүл мэндийн зохих тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах (Афганистан) | -Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг эрчимжүүлж үргэлжлүүлэх,<br><br>-Хөдөө, орон нутгийн болон бага орлоготой хүүхдэд үзүүлж байгаа анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг үнэлэх | -Үзлэгийн тоог нэмэгдүүлж, илрүүлэлт сайжирсан байна.<br><br>-Үнэлгээний тайлан, зөвлөмжийг үндэслэн цаашид хэрхэх талаар тодорхой санал боловсруулан батлуулсан байна. | | |
| 70. | 116.149. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх хүч чармайлтаа бэхжүүлэх (Ирак) | -Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга барилд залуу эцэг эхчүүдийг дадлагажуулах, энэ чиглэлээр үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх, чадавхжуулах, | -Үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, | “Монголын цахилгаан холбоо” ХК. |
| 71. | 116.158.Хууль, олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх замаар гэр бүл болон сургуулийн орчинд бие | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | махбодийн шийтгэлийг таслан зогсоох чиглэлээр хүч чармайлтаа нэмэгдүүлэх (Монтенегро) | -Ерөнхий боловсролын сургуулиудад бүх үүрэн телефоны дугаар руу үнэгүй залгах боломжтой "Итгэлтэй утас" буюу таксофон байршуулах санаачилгыг өргөжүүлэн, орон даяар шат дараалалтай хэрэгжүүлэх. | -"Итгэлтэй утас" байршуулсан сургуулийн тоо нэмэгдсэн байна. | Цахим хөгжил, харилцаа холбооны яам. | |
| 72. | 116.152.Хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн эсрэг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх нэмэлт арга хэмжээ авах, тухайлбал урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх (ХБНГУ) | -Холбогдох салбарын албан хаагчид, хохирогчид үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх, давтан сургах,<br><br>-Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг сурталчлан таниулах, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах. | -Сургалт зохион байгуулсан байна.<br><br>-Сурталчлан таниулах үйл ажиллагаа, сургалтын тоо нэмэгдэж, тайлан гаргасан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Цагдаагийн ерөнхий газар. |
| 73. | 116.153.Хүүхдийг аюултай орчинд ажиллуулахгүй байх нөхцөлийг баталгаажуулж, хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн мөлжлөгтэй тэмцэх (Итали) | | | | |
| 74. | 116.155.Хүүхдийн эрхийн хамгаалалтыг сайжруулах, ялангуяа хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх чиглэлээр хүч чармайлтаа бэхжүүлэх (Румын) | | | | |
| 75. | 116.156.Хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хүн хүч, техник, санхүүгийн хангалттай нөөцөөр хангах (Бельги) | | | | |
| 76. | 116.160.Хүүхдийг бүх төрлийн хүчирхийлэл, мөлжлөг, ялангуяа хүүхдийн хөдөлмөрөөс хамгаалах талаар арга хэмжээ үргэлжлүүлэн авах (Норвеги) | -Хичээлийн жил бүр "Хүүхэд хамгааллын бодлого"-ын хэрэгжилтэд үнэлгээ хийж, үр дүнд тулгуурлан хүүхэд хамгааллын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. | -Жил бүр хүүхэд хамгааллын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | Төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллага. |
| 77. | 116.154.Хүүхдийг бие махбодийн болон сэтгэлзүйн хүчирхийллээс хамгаалах, хүүхэд аюултай, хортой нөхцөлд хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүч чармайлтаа нэмэгдүүлэх (БНСУ) | | | | |
| 78. | 116.159.Хүн, ялангуяа хүүхэд худалдаалахтай тэмцэх чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Тунис) | -Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр | -Хүүхэд хамгааллын компакт гэрээг хэрэгжүүлсэн | Хууль зүй, дотоод хэргийн яам, | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн Хүүхэд хамгааллын компакт гэрээг АНУ-ын Засгийн газрын санхүүжилтээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. | байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба. |
| Зургаа.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр | | | | | |
| 79. | 116.58. Хүн худалдаалах гэмт хэргийг үр дүнтэй мөрдөн шалгах, ял шийтгэл оногдуулах, хохирогчдод илүү сайн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль сахиулах болон шүүхийн тогтолцоог бэхжүүлэх (Канад) | -Цагдаа, прокурор, шүүгч нарын "хохирогч төвтэй" хэрэг хянан шийдвэрлэх хандлага, арга зүйд сургах хамтарсан сургалтыг зохион байгуулах,<br><br>-Өмгөөлөгчдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр мэргэшүүлэх. | -50-аас доошгүй албан хаагчийг сургаж мэргэшүүлсэн байна.<br><br>-30-аас доошгүй өмгөөлөгчийг сургаж мэргэшүүлсэн байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба,<br><br>Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Хууль зүйн үндэсний хүрээлэн,<br><br>Улсын ерөнхий прокурорын газар,<br><br>Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн,<br><br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв,<br><br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Улсын дээд шүүх. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хүрээлэн. | |
| 80. | 116.59.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг үргэжлүүлэх (Иран) | -Гэмт хэргийн хохирогч хүүхдээс мэдүүлэг авах хүүхдэд ээлтэй жишиг өрөө тохижуулах,<br><br>-Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хохирлыг бодитойгоор нөхөн төлүүлэх талаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. | -Хүүхдэд ээлтэй 3 жишиг өрөө байгуулсан байна.<br><br>-Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба. |
| 81. | 116.65.Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахтай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үндэсний үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг нэгтгэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах (Венесуэл) | | | | |
| 82. | 116.60.Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах (Ирак) | -Энэ төрлийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох хүрээнд зочид буудал, дэн буудал, саун, массаж, жуулчны баазын ажилтнуудыг сургах, давтан сургах,<br><br>-Энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлтийг сайжруулах хүрээнд хил хамгаалах, Засгийн газрын хяналт, гадаадын иргэний асуудал хариуцсан байгууллагын албан хаагчид, эмч, багш нарыг сургах, давтан сургах,<br><br>-Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох. | -200-аас доошгүй зочид буудал, дэн буудал, саун, массаж, жуулчны баазын ажилтнуудыг сургасан байна.<br><br>-100-аас доошгүй төрийн албан хаагчийг сургасан байна.<br><br>-Хуульд заасны дагуу баталсан 2-оос доошгүй журмыг хянаж, шинэчилсэн байна. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар. |
| 83. | 116.62.Төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагын болон цагаачлалын ажилтнууд, прокуроруудад мэргэшлийн сургалт явуулах, хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн байцаах, яллах, шийтгэл оногдуулах, энэ гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх (Мексик) | | | | |
| 84. | 116.61.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг нөхөн сэргээх, хамгаалах байраар хангах зэрэг замаар хохирогчдын хамгаалалтыг сайжруулж, хохирлоо нөхөн төлүүлэх бололцоог бүрдүүлэх (Малайз) | -Хамгаалах байрны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хохирогчид санхүүгийн хувьд бие даахад дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, ажлын байранд зуучлах. | -20-оос доошгүй хохирогчид санхүүгийн хувьд бие даахад дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, ажлын байранд зуучилсан байна. | Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яам. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх |
| 85. | 116.63.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хамгаалалтыг сайжруулж, хохирлоо нөхөн төлүүлэх арга механизмыг бүрдүүлэх (Нигер) | | | | |
| 86. | 116.66.Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүний дотор Эрүүгийн хэрэг хянан | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэх тухай хуулийн 8.1-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг түргэтгэх замаар прокуророос хүн худалдаалах гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаа этгээдүүдийн эсрэг хэрэг үүсгэсэн эсэхээс үл хамааран хохирогчид хамгаалах үйлчилгээ авах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах (Бахам) | | | | ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба,<br><br>Төрийн бус байгууллага. |
| 87. | 116.67.Төрийн албан хаагчдад зориулсан мэргэшлийн сургалт явуулах зэргээр хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахтай тэмцэх, гэмт этгээдэд шийтгэл оногдуулах нөхцөлийг баталгаажуулж хууль сахиулах үйл ажиллагааг сайжруулах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод иж бүрэн тусламж үзүүлэх, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах зэрэг замаар хүч чармайлтыг улам эрчимжүүлэх (Беларусь) | | | | |
| 88. | 116.64.Орчин цагийн боолчлолын бүх хэлбэрийг гэмт хэрэгт тооцох чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг сайжруулан бэхжүүлэх, үүнд хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай НҮБ-ын протоколтой нийцүүлэн хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцох (ИБУИНХУ) | -Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцсон. | -Хэрэгжсэн. | Хууль зүй, дотоод хэргийн яам. | |
| | Долоо.Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр | | | | |
| 89. | 116.69.Гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах зэрэг замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд ямарваа шийтгэл хүлээхээс айж эмээх зүйлгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын стандартын дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах (Эстони) | -Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга)-ийг боловсруулах,<br><br>-Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг үйлдсэн халдлагыг мөрдөн шалгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх зорилгоор хууль, эрх зүйн орчныг сайжруулах, халдлагыг мөрдөн шалгах үйл ажиллагааг бэхжүүлэх. | -Хуулийн төсөл боловсруулсан байна.<br><br>-Холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, зохицуулалтыг сайжруулах санал боловсруулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар. | |
| 90. | 116.71.Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагыг хараат бусаар мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд шийтгэл хүлээлгэх (Австрали) | | Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны эсрэг үйлдэгдсэн халдлагын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, хараат бусаар шалгаж шийдвэрлэх механизмыг бэхжүүлсэн байна. | | |
| 91. | 116.70.Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийг хүчингүй болгох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах (ИБУИНХУ) | -Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон. | -Хэрэгжсэн. | Хууль зүй, дотоод хэргийн яам. | |
| | Найм.Ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр | | | | |
| 92. | 116.26.Шүүхэд болон захиргааны зэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх үр дүнтэй хууль, эрх зүйн эх сурвалж бий болгох үүднээс төр болон хувийн хэвшлийн салбар дахь шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалттай тэмцэх цогц хууль батлах асуудлыг авч үзэх (Чили) | -Олон улсад шинэ төрлийн гэмт хэргээр бүртгэгдэж буй "үзэн ядах" гэмт хэргийн талаарх ойлголтыг судалж, эрүүгийн хууль тогтоомжид тусгах талаар дүгнэлт, санал боловсруулах. | -Судалгаа хийх, дүгнэлт, санал гаргах,<br><br>-Дүгнэлт, саналын мөрөөр холбогдох шийдвэрийн төслийг боловсруулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам. | Хууль зүйн үндэсний хүрээлэн. |
| 93. | 116.28.Шууд болон шууд бус ялгаварлан гадуурхах асуудлыг зохицуулж, ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэр, тэр дундаа хүйсийн болон бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон цогц хууль батлах (Исланд) | | | | |
| 94. | 116.27.Ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх талаарх хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээг бэхжүүлэх (Аргентин) | -Ялгаварлан гадуурхалтыг хориглон зохицуулж буй хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор хууль сахиулах салбарын алба хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах,<br><br>-Эрүүл мэнд, шүүгч, хууль сахиулах чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт | -Жилд нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.<br><br>-Сургалтын хөтөлбөрт холбогдох агуулгыг | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Эрүүл мэндийн яам. | Төрийн бус байгууллага,<br><br>Аймаг, нийслэлийн ЭМГ. |
| 95. | 116.30.Хүмүүсийг бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдал, хүйсийн илэрхийлэл зэргээр ялгаварлан гадуурхах, дарамт шахалт үзүүлэхээс хамгаалах хуулийн заалтыг улам боловсронгуй болгох, хэрэгжүүлэх | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | (Израиль) | ЛГБТИ хүмүүсийн онцлог, тэдний талаарх нийгэмд буй хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаарх агуулгыг тусгах, сургалт зохион байгуулах,<br><br>-ЛГБТИ хүмүүсийн талаар нэгдсэн судалгааг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран хийх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гарцыг хайх ажлыг эхлүүлэх. | тусгаж, сургалт явуулсан байна.<br><br>-Судалгаа хийж, дүгнэлт, зөвлөмж гарсан байна. | | |
| 96. | 116.36.Бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхах, үзэн ядах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр шинээр бий болсон хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх (Испани) | | | | |
| 97. | 116.38.ЛГБТИ хүмүүсийн эсрэг үзэн ядах гэмт хэрэгтэй холбоотой хэрэг зөрчлийн талаар хуульч, хууль сахиулах байгууллагын алба хаагчдыг үргэлжлүүлэн сургах, холбогдох хуулийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх (Австрали) | | | | |
| 98. | 116.35.Хүний эрх, ялгаварлан гадуурхах, түүний дотор бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар нь ялгаварлахтай тэмцэх сэдвээр эрүүл мэндийн ажилтнууд, шүүгч, цагдаагийн алба хаагчид, хорих байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгуулах (Португал) | | | | |
| 99. | 116.29.ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүлээцтэй байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг эхлүүлэх (Исланд) | | | | |
| 100. | 116.34.Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, хууль сахиулах байгууллагуудад үр дүнтэй сургалт зохион байгуулах замаар ЛГБТИ хүмүүсийн талаарх хэвшмэл, өрөөсгөл ойлголттой тэмцэх (Нидерланд) | | | | |
| 101. | 116.33.ЛГБТИ залуучуудын аюулгүй орчныг хангах, боловсролын байгууллага, эсхүл үе тэнгийнхнээрээ шоолуулахаас айлгүйгээр хөгжих, өөрийгөө илэрхийлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа зэрэг ойлголтыг багтаасан ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлогыг нэвтрүүлэх | -Залуучуудын хөгжил, оролцоог дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээнд бэлгийн чиг хандлагын талаарх зөв ойлголт, ялгаварлан гадуурхалтын эсрэг агуулгыг тусгах, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх,<br>-ЛГБТИ хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хүлээцтэй байдлыг | -Сургалт, нөлөөллийн арга хэмжээний агуулгад тусгасан байна.<br><br>-Жилд нэгээс доошгүй удаа үйл ажиллагаа зохион | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br>Хууль зүй, дотоод хэргийн яам,<br>Эрүүл мэндийн яам. | Төрийн бус байгууллага. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | (Нидерланд) | хөхиүлэн дэмжих зорилгоор олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах,<br><br>-Глобал сантай хамтран ХДХВ-ийн халдварт өртөх өндөр эрсдэлт бүлгийн иргэдийг ХДХВ-ийн урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулах,<br><br>-ЛГБТИ хүмүүст чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх талаар судалгаа хийх | байгуулсан байна.<br><br>-Урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулсан байна.<br><br>-ЛГБТИ хүмүүст чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх талаар судалгаа гарсан байна. | | |
| 102. | 116.37. Тогтвортой хөгжлийн зорилт 5.2 ба 16.1-д нийцүүлэн гэр бүлийн хүчирхийлэл, ЛГБТИ бүлгийн эсрэг хүчирхийллийн талаар мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ авах (Швейцар) | | | | |
| 103. | 116.39. ЛГБТИ хүмүүсийн талаарх өрөөсгөл ойлголтыг арилгах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг хангах талаар хүч чармайлт гаргахад анхаарах (Тайланд) | | | | |
| 104. | 116.40. Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг арилгаж, гадаадын иргэдийн эсрэг үзэн ядах үг хэллэг хэрэглэх явдлыг багасгах (Египет) | -Арьс үндсээр алагчлах, ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг мөрдөн шалгах ажлыг нэмэгдүүлэх,<br><br>-ЛГБТИ хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, гэмт хэргийн талаарх мэдээллийн бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх боломжийг судлах,<br><br>-ЛГБТИ хүмүүсийн онцлог, тэдний талаарх ойлголтын зөрүүг арилгах талаар хууль сахиулах байгууллагын алба хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах. | -Гомдол, мэдээллийг хууль тогтоомжийн дагуу шалгасан байна.<br><br>-Мэдээллийн бүртгэлийн тогтолцоог бий болгох судалгаа хийж, холбогдох арга хэмжээ авсан байна.<br><br>-Сургалт зохион байгуулсан байна. | Цагдаагийн ерөнхий газар. | Хууль зүй, дотоод хэргийн яам. |
| 105. | 116.32. ЛГБТИ хүмүүсийн эсрэг хэвшмэл, өрөөсгөл ойлголтын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлж, энэ бүлгийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулах (Люксембург) | | | | |
| 106. | 116.31. Монгол Улсын Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан трансжендэр болон интерсекс хүмүүс хүйсээ хууль ёсоор бүртгүүлэхэд эмнэлгийн байгууллагын нотолгоо баримт бичиг авсан байх тухай шаардлагыг хүчингүй болгох (Израиль) | | | | |
| | Ес.Олон улсын гэрээнд нэгдэн орох, дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг сайжруулах, хүний эрхийн олон улсын механизмтай хамтран ажиллах чиглэлээр | | | | |
| 107. | 116.1.Үндэсний хууль тогтоомжийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нийцүүлэх, эрх зүйн шинэтгэл явуулахдаа иргэний нийгмийн оролцоог хангах (Украин) | -Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах,<br><br>-Хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, олон улсын тухайн гэрээний байгууллагаас өгсөн дүгнэлт, | -Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу | Хууль зүй, дотоод хэргийн яам. | Бүх яам. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зөвлөмжийг харгалзан хууль тогтоомжийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэх арга хэмжээ авах. | сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.<br><br>-Хууль тогтоомжийг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлж, нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. | | |
| 108. | 116.2.Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээнд гарын үсэг зурж, нэгдэн орох (Гондурас) | -Улсын Их Хурал Цөмийн зэвсгийг хориглох тухай гэрээг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр соёрхон баталсан. | -Хэрэгжсэн. | Гадаад харилцааны яам. | |
| 109. | 116.5.Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн хоёр дахь илтгэлийн мөрөөр байгуулсан орон тооны бус зөвлөлийг хүний эрхийн бүх зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайлагнах, мөрөөр ажиллах асуудал хариуцсан байнгын ажиллагаатай яам хоорондын механизм болгож шинэчлэн байгуулах (Португал) | -Хүний эрхийн төлөв байдлын илтгэлийн мөрөөр байгуулагдсан орон тооны бус зөвлөлийг бэхжүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах,<br><br>-Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, тухайн гэрээний байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ хийх, тайлагнах үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулах, салбар дундын зохицуулалтыг бэхжүүлэх. | -Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, чадавхыг бэхжүүлсэн байна.<br><br>-Хууль, журмын төсөл боловсруулсан байна. Олон улсын гэрээ, зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ авсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Гадаад харилцааны яам. | Холбогдох төрийн байгууллага,<br><br>Хүний эрхийн үндэсний комисс. |
| 110. | 116.6.Хүний эрхийн олон улсын гэрээний байгууллага, механизмаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайлагнах, мөрөөр ажиллах асуудал эрхэлсэн байнгын ажиллагаатай бүтэц /NMIRF/ бий болгох (Бахам) | | | | |
| 111. | 116.7.Хүний эрхийн олон улсын байгууллага, тэр дундаа Хүний эрхийн зөвлөлийн тусгай процедур, гэрээний байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллах (Пакистан) | -НҮБ-ын хүний эрхийн байгууллага, тэр дундаа Хүний эрхийн зөвлөлийн тусгай процедур, гэрээний байгууллагуудтай үргэлжлүүлэн хамтран ажиллах. | -Тусгай бүтэцтэй хамтын ажиллагааг үргэлжлүүлж, айлчлалыг зохион байгуулсан байна. | Гадаад харилцааны яам. | |
| 112. | 116.8.НҮБ-ын гэрээний хороодын сонгуульд нэр дэвшүүлэхдээ мерит зарчимд суурилсан нээлттэй сонгон шалгаруулалт явуулдаг болох (ИБУИНХУ) | -НҮБ-ын төрөлжсөн байгууллага, тусгай бүтэц, гэрээний хороодын сонгуульд нэр дэвшүүлэх нээлттэй сонгон шалгаруулалтын журам бий болгох. | -Журам боловсруулж, батлуулсан байна. | Гадаад харилцааны яам. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 113. | 116.9.Үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын стандартад нийцүүлэх ажлыг үргэлжүүлэх (Венесуэл) | -Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн дагуу боловсруулж буй хуулиудыг хүний эрхийн олон улсын стандартад нийцүүлэх | -Хуулийн төслүүдийг судалж, санал, дүгнэлт өгсөн байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам. | Бүх яам. |
| 114. | 116.42.2019 онд эхлүүлсэн үйл явцыг үргэлжлүүлэн Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах хүч чармайлтыг эрчимжүүлэх (Чили) | -НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр баталсан. | -Хэрэгжсэн. | Гадаад харилцааны яам. | Бүх яам, холбогдох байгууллага. |
| 115. | 116.43.НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмын дагуу Бизнес ба хүний эрхийн үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад холбогдох бүх этгээд, ялангуяа иргэний нийгмийг оролцуулах (Швейцар) | | | | |
| | Арав.Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр | | | | |
| 116. | 116.80.Шүүхийн бие даасан байдлыг бэхжүүлэх, ялангуяа 2019 оны 3 дугаар сард батлагдсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай, Прокурорын тухай болон Авлигын эсрэг хуульд тус тус оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгох (Франц) | -Шүүхийн бие даасан байдлыг хангахтай холбоотойгоор шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хангах буюу төсвийн хөрөнгийг зохих түвшинд хүргэж нэмэгдүүлэх,<br><br>-Шүүхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг нэг мөр, зөв хэрэглэх, хэрэгжилтэд хяналт тавьж, бодитоор хэрэгжих нөхцөл, боломжоор хангах. | -Шүүхийн төсвийг нэмэгдүүлэх талаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.<br><br>-Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам. | Шүүхийн ерөнхий зөвлөл. |
| 117. | 116.81.Шүүхийн бие даасан байдал, үйл ажиллагааны ил тод, чөлөөт байдлыг баталгаажуулахад чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Ирак) | | | | |
| 118. | 116.83.Шүүхийн тогтолцооны хараат бус, бие даасан байдлыг бүрэн хангах хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Перу) | | | | |
| 119. | 116.87.Шүүхийн тогтолцооны хараат бус, бие даасан байдлыг хангахын тулд хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, журмыг шинэчлэх зэрэг арга хэмжээ авах (Бразил) | -Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх, шийдвэрлэх журам, Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах журмыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах. | -Журмыг хэрэгжүүлсэн байна. | Шүүхийн ерөнхий зөвлөл. | Хууль зүй, дотоод хэргийн яам. |
| 120. | 116.82.Шүүхийн хараат бус, ил тод байдлыг хангах, хууль сахиулах үйл ажиллагаа тодорхой байх нөхцөлийг | -Шүүн таслах ажиллагааны үр нөлөөг сайжруулахын тулд шүүхийн үйл ажиллагааг цахимжуулахыг эхлүүлэх, | -Шүүхийн үйл ажиллагааг цахимжуулахыг | Хууль зүй, дотоод хэргийн яам. | Шүүхийн ерөнхий зөвлөл. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулахад чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Япон) | бэхжүүлэх. | эхлүүлсэн байна. | | |
| 121. | 116.85.Шүүхийн бие даасан байдлыг хамгаалах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авч, шүүгч, прокурорыг томилох үйл явцыг ил тод, хараат бус байлгах (Чех) | -Шүүгчийг томилох, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах ажиллагааг шударга, ил тод байдлыг хангаж зохион байгуулах, тэдгээрийг сонгон шалгаруулахад мэдлэг, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, шатлан дэвших зарчмыг баримтлах тогтолцоог бэхжүүлэх. | -Шүүгчийг сэлгэн ажиллуулах журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Шүүхийн ерөнхий зөвлөл. | Авлигатай тэмцэх газар. |
| 122. | 116.86.Хууль зүйн хамгаалалтыг тууштай хэрэгжүүлж, шүүгч болон бусад албан тушаалтныг дур зоргоор ажлаас нь халахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хамгаалалтын арга хэмжээ бий болгох зэрэг замаар шүүхийн бие даасан байдал, авлигын эсрэг хяналтыг бэхжүүлэх (АНУ) | | | | |
| 123. | 116.84.Алслагдмал нутаг дэвсгэрт хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс хууль, эрх зүйн болон шүүхийн шинэтгэл хийх чиглэлээрх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх (ОХУ) | -Хууль зүйн туслалцааны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг сурталчлан таниулах, иргэд олон нийтэд мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа зохион байгуулах. | -Сурталчлан таниулах, мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Хууль зүй, дотоод хэргийн яам. | Хууль зүйн туслалцааны төв,<br><br>Бүх шатны Засаг дарга. |
| 124. | 116.88.Шүүхийн шударга, ил тод байдлыг хангах, эрүүдэн шүүхэд оролцсон этгээдэд хариуцлага оногдуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернетийн хэрэглээнд тогтоосон хязгаарлалтыг цуцлах талаар шаардлагатай хүч чармайлт гаргах (Египет) | -Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаарх төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах, байгууллага, албан тушаалтны зүгээс хүний хувийн мэдээлэл цуглуулах, хувь хүний харилцаа холбоог хянах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах. | -Мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. Байгууллага, албан тушаалтны зүгээс хүний хувийн мэдээлэл цуглуулах, хувь хүний харилцаа холбоог хянах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах талаар дүгнэлт, санал боловсруулж, зохих арга хэмжээ авсан байна. | Цахим хөгжил, харилцаа холбооны яам. | |
| | Арван нэг.Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх эрхийг хангах чиглэлээр | | | | |
| 125. | 116.100.Нийтийн эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг улам бүр сайжруулах | -"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөний | -Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, | Эрүүл мэндийн яам. | Аймаг, нийслэлийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | (БНХАУ) | хэрэгжилтийг эрчимжүүлэх. | тайлан. | | ЭМБ. |
| 126. | 116.101.Эх, нялхсын эрүүл мэндийн салбарт гарсан томоохон ахиц дэвшлийг үргэлжлүүлж, өдгөө хэрэгжиж буй бодлого, стратегийг цааш үргэлжлүүлэн нэн ялангуяа нярай хүүхдийн асаргаа, нөхөн үржихүйн эрүүл мэнд, дархлаажуулалт, хөхөөр хооллолтыг дэмжих зэрэг чиглэлээрх хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх (Куба) | | | | |
| 127. | 116.102.Эх, хүүхдийн эрүүл мэндийг хөхиүлэн дэмжих хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Оман) | -"Хүүхэд яагаад эндэв?" судалгаа хийж, судалгааны үр дүнг танилцуулах,<br><br>-Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн хэрэгжилтийн үнэлгээг сонгосон ЭМБ-д хийх. | -Судалгааны тайлан, зөвлөмж гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.<br><br>-Үнэлгээний тайлан, зөвлөмж гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна. | Эрүүл мэндийн яам. | Аймаг, нийслэлийн ЭМБ. |
| 128. | 116.103.Үндэсний эрүүл мэндийн дэд бүтцийг нэн ялангуяа эх, хүүхдийн эрүүл мэндийн салбарт үргэлжлүүлэн бэхжүүлэх (Венесуэл) | -Эх барихын яаралтай тусламжийн үр чадварын өрөөг алслагдсан 20 сумын эрүүл мэндийн төвд байгуулах,<br><br>-Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламжийн чиглэлээр алгоритм боловсруулах, сургалт зохион байгуулах,<br><br>-Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж, үйлчилгээг үзүүлэх, сургуулийн эмч, эрүүл мэндийн анхан шатны эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах. | -Шинээр байгуулсан эх барихын яаралтай тусламжийн өрөөний тоо.<br><br>-Боловсруулсан алгоритмын тоо, зохион байгуулсан сургалтын тоо, тайлан.<br><br>-Зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлгийн тоо, тайлан.<br>-Дэмжлэг үзүүлсэн өсвөр үеийн кабинетын тоо. | Эрүүл мэндийн яам. | Аймаг, нийслэлийн ЭМБ. |
| 129. | 116.104.Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн талаарх насны онцлогт тохирсон боловсролыг | -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн "Сургалтын | -Сургалтын хөтөлбөрийн агуулгад дүн | Боловсрол, шинжлэх ухааны яам. | Эрүүл мэндийн яам. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах (Фижи) | хөтөлбөр батлах тухай" А/467 дугаар тушаалаар баталсан эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд шинэчилж сайжруулах арга хэмжээ авах | шинжилгээ хийж, сайжруулсан байна. | | |
| 130. | 116.106.Хүүхдийн насны онцлогт тохирсон бэлгийн боловсрол олгох цогц сургалтын хөтөлбөр баталж ерөнхий боловсролын сургалтын туршид хэрэгжүүлэх, уг хөтөлбөрт хүчирхийллийн асуудлыг мөн тусгаж оруулах (Исланд) | | | | |
| 131. | 116.105.Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн тухай мэдээлэл, бараа, үйлчилгээ авах боломжоог бүрдүүлэх замаар охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах, хүчээр үр хөндүүлэх, албадан үргүйжүүлэх явдлыг таслан зогсоох (Исланд) | -Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтан нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлага, ойлголтыг сайжруулах | -Хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлага, ойлголтыг нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | |
| | | -Үр хөндөх ажилбар хийж байгаа эрүүл мэндийн байгууллагын үр хөндөлтийн тусламж үйлчилгээг үнэлж, дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах,<br><br>-Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн хор уршиг, гэр бүл төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгуулах, мэдээлэл сургалт, сурталчилгаа зохион байгуулах. | -Үр хөндөлтийн тусламж, үйлчилгээний асуудлаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталсан байна.<br><br>-Сургалт, сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн яам. | |
| 132. | 116.107.Бүх эмэгтэйчүүд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл, үйлчилгээ авах боломжоог бүрдүүлж, тэд эдгээр бүх үйл явцад шийдвэрээ мэдээллийн үндсэн дээр чөлөөтэй гаргах эрхийг нь хангах (Мексик) | -Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслээр хангахад зориулсан зардлыг улсын төсөвт үе шаттай нэмэгдүүлэн тусгаж, анхан шатны нэгжээр дамжуулан зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насныханд хүргэх,<br><br>-Хот, суурин газарт шилжин суурьшигч болон оюутан, залуучууд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа зохион байгуулах. | -Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийг зорилтот бүлгийнхэнд үнэ төлбөргүй хүргэж эхэлсэн байна.<br><br>-Гэр бүл төлөвлөлтийн талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн яам. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 133. | 116.122.Эмнэлзүйн удирдамж, эмчилгээний стандартаас охид, эмэгтэйчүүдийг бэлгийн харьцаанд орсон эсэхийг тодорхойлохтой холбоотой шаардлагыг хасаж, тэдний эрхийг хангах (Австрали) | -Эрүүл мэндийн сайдын 2019 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” А/385 тоот тушаалыг шинэчлэн 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн “Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж үйлчилгээ үзүүлэх заавар” А/364 тоот тушаалыг баталж, холбогдох заалтыг хассан. | -Хэрэгжсэн. | Эрүүл мэндийн яам. | |
| 134. | 116.121.Жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэх, охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх, түүний дотор эрүүл мэндийн анхан шатны тусламж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхийг хангах талаар хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Тунис) | -Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд жендэрийн үзэл баримтлалын талаар сургалт зохион байгуулах,<br><br>-Жендэрт суурилсан хүчирхийлэлд хохирогчдод эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдийн мэдлэг, чадварыг сайжруулах сургалтад бүх аймаг, дүүрэг, сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагыг хамруулах. | -Сургалт зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн яам. | |
| 135. | 116.94.Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг сайжруулж иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бодитой хангах чиглэлээр улам бүр хүч чармайлт гаргах (БНАСАУ) | -Ахмад настны тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг дэмжих төсөл хэрэгжүүлэх. | -Төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | |
| 136. | 116.20.Ард иргэд, тэр дундаа нэн эмзэг бүлгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулахын тулд халамж, нийгмийн хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн бэхжүүлэх (Вьетнам) | -Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгааны дүнгээр ядуурлын шугамаас доогуур орлоготой өрх, иргэнийг нийгмийн халамжийн хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулах, шаардлагатай тусламж, үйлчилгээг хүргэх. | -Зорилтот бүлгийн иргэдийг халамжийн хөтөлбөрт хамруулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | |
| 137. | 116.95.Ядуурлын түвшингээс доогуур амьдарч байгаа бүлэгт нийгмийн халамж үзүүлэхэд чиглэсэн бодлогыг үргэлжлүүлэх (Оман) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Арван хоёр.Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр | | | | | |
| 138. | 116.21.Хүний эрхийн үндэсний комиссын эрх хэмжээ, түүний дотор үндэсний урьдчилан сэргийлэх механизмыг шинэ хууль тогтоомжийн дагуу улам бүр бэхжүүлэх (Гүрж) | -Хүний эрхийн үндэсний комисс хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх нөхцөлийг хангах,<br><br>-Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, холбогдох журмуудыг батлах. | -Комиссын үйл ажиллагааг бэхжүүлэх талаар саналаа эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авсан байна.<br><br>-Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн дагалдах журмуудыг батлуулсан байна. | Хүний эрхийн үндэсний комисс. | |
| 139. | 116.22.Парисын зарчмын дагуу Хүний эрхийн үндэсний комиссыг бэхжүүлэхэд анхаарах (Энэтхэг) | | | | |
| 140. | 116.23. Парисын зарчимд бүрэн нийцүүлэн Хүний эрхийн үндэсний комисст зохих хүний болон санхүүгийн нөөцийг хуваарилах (Казахстан) | | | | |
| 141. | 116.24.Хүний эрхийн салбарт хүртээмжтэй, цогц хандлагыг бий болгох зорилгоор бүс нутаг дахь хүний эрхийн үндэсний байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх (Армени) | | | | |
| 142. | 116.13.Хүний эрх хамгаалагчид хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээрх үйл ажиллагаагаа чөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс тэднийг хүлээн зөвшөөрч, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж баталж, хэрэгжүүлэх (Ирланд) | -Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Хүний эрхийн үндэсний комиссын дэргэдэх Хүний эрх хамгаалагчийн хороо, хорооны нэгжийг байгуулж, шаардлагатай хүн хүч, нөөцөөр хангах. | -Хүний эрх хамгаалагчийн хороо, хорооны нэгжийг байгуулж, гишүүд, нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулж, томилсон байна. | Хүний эрхийн үндэсний комисс. | |
| 143. | 116.72.Хүний эрх хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагуудыг заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамтлахаас хамгаалсан хууль тогтоомж баталж, хэрэгжүүлэх, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагын хэргийг мөрдөн шалгах, буруутай этгээдэд хариуцлага оногдуулах (Чех) | | | | |
| 144. | 116.14.Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах тухай хуулийн төслийг аль болох хурдан эцэслэн батлах (Швейцар) | | | | |
| 145. | 116.76.Хүний эрх хамгаалагчдыг халдлага, заналхийлэл, сүрдүүлгээс хамгаалах (Франц) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 146. | 116.77.Хүний эрх хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгчийн өгсөн зөвлөмжийн дагуу Хүний эрх хамгаалагчдын тухай хуулийн төслийг сайжруулах, батлах замаар хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах (ХБНГУ) | | | | |
| 147. | 116.15.Үндэсний болон салбарын үндсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх замаар олон улсын үүрэг амлалтаа биелүүлэх чиглэлээр хүч чармайлтаа үргэлжлүүлэх (БНАСАУ) | -Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний түвшинд төлөвлөж хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх,<br><br>-Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах анги, их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт туссан хүний эрхийн боловсролын агуулгыг амжилттай хэрэгжүүлэх. | -Дэлхийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.<br><br>-Хүний эрхийн боловсрол олгох хичээлийн агуулгыг нутагшуулж, амжилттай хэрэгжүүлсэн байна. | Боловсрол, шинжлэх ухааны яам. | Холбогдох яам,<br><br>Хүний эрхийн үндэсний комисс. |
| 148. | 116.25.Хүний эрхийн боловсролыг төрийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгон нэгтгэх арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Пакистан) | | | | |
| | Арван гурав.Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр | | | | |
| 149. | 116.45.Ашигт малтмалын үйл ажиллагааны зөвшөөрөл олгох үйл явцад хүний эрх, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, төслийн нөлөөлөлд өртөх бүх хүнийг үнэлгээний үйл явцад үр дүнтэй оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх (Чили) | -Уул уурхайн төслүүдэд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, аудит хийж, байгаль орчны бохирдол доройтлыг бууруулах,<br><br>-Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал, журмыг шинэчлэх (нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээний асуудлыг тусгах),<br><br>-Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийг шинэчлэн байгуулах,<br><br>-Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн уялдаа холбоог хангаж боловсронгуй болгох, | -Уул уурхайн төслүүдэд аудит хийсэн байна.<br><br>-Журмыг шинэчлэн, хэрэгжүүлсэн байна.<br><br>-Зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна.<br><br>-Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам,<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,<br><br>Ашигт малтмал, газрын тосны газар,<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | -Төслийн нөлөөлөлд өртөх этгээдийн үнэлгээг хийх зорилгоор ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлын үнэлгээ хийж, байгаль орчны үнэлгээнд тусгадаг байх асуудлыг судалж шийдвэрлэх,<br><br>-Ашигт малтмалын үйл ажиллагаа явагдах бүс нутаг, газарт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 30 хувиас доошгүй хувийг төвлөрүүлдэг болох эрх зүйн орчныг бүрдүүлэх. | -ХАБ-ын үнэлгээг байгаль орчны үнэлгээнд тусгах асуудлыг судалж, дүгнэлт гаргасан байна.<br><br>-Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн талаар судалгаа хийж, дүгнэлт гаргасан байна. | | Сангийн яам. |
| 150. | 116.46.Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцөөр хангах (Сенегал) | -Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, Улаанбаатар хот болон томоохон хот суурин газрын агаар, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ авах,<br><br>-Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоол, мөн түүхий нүүрсний хэрэглээг зохицуулах, хяналт тавих Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажил, арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, биелэлт, үр дүнг дүгнэх. | -Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.<br><br>-Тогтоолуудын хэрэгжилтийг хангаж, үр дүнг дүгнэсэн байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам,<br><br>Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо. | Эрчим хүчний яам,<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,<br><br>Барилга, хот байгуулалтын яам,<br><br>Зам, тээврийн хөгжлийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар. |
| 151. | 116.47.Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон байгаль орчны эрсдэлийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хүч чармайлтаа нэмэгдүүлэх (Тайланд) | | | | |
| 152. | 116.48.Байгаль орчинд тулгамдсан салбар дундын асуудал, түүний дотор уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцоог сайжруулахад шаардлагатай хууль, эрх зүйн орчин бий болгож, бэхжүүлэх хүч | -Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн баримт бичгийн хэрэгжилтийг салбар дундын зохицуулалтаар хангах, үнэлэх, тайлагнах, | -Зохицуулалтыг хангах шийдвэр гарсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам,<br><br>Уур амьсгалын Үндэсний хороо, | Эрчим хүчний яам,<br><br>Барилга, хот байгуулалтын яам, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | чармайлтыг эрчимжүүлэх (Фижи) | -Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулж, чадавхийг бэхжүүлэхэд шаардлагатай төсөв, техник тоног төхөөрөмжийн судалгааг гарган, мэргэжилтнүүдийг тусгайлан бэлтгэх ажлыг зохион байгуулах. | -Гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцоог сайжруулах арга хэмжээ авсан байна. | Монгол Улсын Шадар сайд,<br><br>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам,<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам. |
| 153. | 116.73.Байгаль орчинд хор хохирол учруулснаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох (Франц) | -Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, үйлдвэр, аж ахуйн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх. | -Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам. | Хууль зүй, дотоод хэргийн яам,<br><br>Цагдаагийн ерөнхий газар,<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар. |
| | | Арван дөрөв.Бусад | | | |
| 154. | 116.44.Хүмүүс, ялангуяа малчид, тариаланчдын амьжиргаа, уламжлалт соёл, сайн сайхан аж амьдралыг хадгалахын тулд цэвэр орчин, цэвэр усаар хангагдах эрхийг хамгаалахад чиглэсэн хүч чармайлтыг сайжруулах (Индонез) | -Ундны усны эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг хийж, нөөцийг тогтоож, баталгаажуулах | -15 сумын ундны усны хайгуул судалгааг хийж, нөөцийг тогтоосон байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | |
| 155. | 116.68.Шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, үүнд хууль, эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлж шашны бүлэг, байгууллагуудад чөлөөтэй бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах боломжийг олгох (АНУ) | -Төрийн бус байгууллагын тухай хуулийг боловсронгуй болгох,<br><br>-Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх. | -Хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна. | | Хууль зүй, дотоод хэргийн яам. |
| 156. | 116.74.Төрийн бус байгууллагын бүртгэл, санхүүжилтийн тухай зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Төрийн бус байгууллагын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах (ХБНГУ) | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 157. | 116.75.Иргэний нийгэм, түүний дотор төрийн бус байгууллага, хүний эрх хамгаалагчид, шашны бүлгүүдийн улс төрийн үйл явц болон авлигын эсрэг хүч чармайлтад оролцоог нь нэмэгдүүлэх (АНУ) | | | | |
| 158. | 116.78.Хувь хүний нууцаа хамгаалуулах эрхийг хөхиүлэн дэмжиж, улам сайн хамгаалах зорилгоор өгөгдөл хамгаалах үр дүнтэй хууль тогтоомж батлах, ингэхдээ хууль ёсны бөгөөд тодорхой зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай болон хязгаарлалтын хүрээ нь хэр хэмжээнд нийцсэн байх зарчмыг баримтлах (ХБНГУ) | -Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авах. | -Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хангах арга хэмжээ зохион байгуулсан байна.<br><br>-Хуулийн төсөл боловсруулсан байна. | | |
| 159. | 116.79.Хүүхэд, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг нь бүрэн баталгаажуулсан хууль, эрх зүйн орчин бий болгох (Бельги) | | | | |
| 160. | 116.92.2021 онд болох ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан сонгуулийн үйл явцыг хангах (Эстони) | -Сонгуулийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан. | -Хэрэгжсэн. | Сонгуулийн ерөнхий хороо. | |
| 161. | 116.98.Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажлын байрны бэлгийн дарамтыг хориглох тухай заалт оруулах асуудлыг судлан үзэх (Эстони) | -Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д туссан ажлын байрны бэлгийн дарамтыг хориглохтой холбоотой журам, зохицуулалтыг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах | -Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Хууль зүй, дотоод хэргийн яам. |
| 162. | 116.114.Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хуульд ажлын байрны бэлгийн дарамтыг хориглохтой холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг замаар охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад чиглэсэн цогц хууль тогтоомж батлах (Ирланд) | | | | |
| 163. | 116.99.Малчид, залуучуудын дунд ажилгүйдлийн түвшинг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээ сайжруулах (Мьянмар) | -"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" болон "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн | -Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх. | | | |
| 164. | 116.41."Тогтвортой хөгжлийн зорилт-2030"-д туссан чухал зорилтуудыг биелүүлэхийн тулд ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн салбар хоорондын хэрэгжилтийг бэхжүүлэх (Куба) | -Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 159 дүгээр тогтоолоор баталсан "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | -Үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. | Засгийн газрын холбогдох агентлаг. |
| 165. | 116.89.2019 онд батлагдсан "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг бүрэн хэрэгжүүлж, Монгол Улсын үндэсний хөгжил дэвшил, ард иргэдийн сайн сайхан байдлыг хангахын тулд авлигатай тэмцэх чиглэлээрх хүч чармайлтаа үргэлжлүүлэх (Индонез) | | | | |
| 166. | 116.96.Иргэдийн зохистой орон байраар хангагдах эрхийг баталгаажуулахад онцгой анхаарч ядууралтай тэмцэх, нийгмийн даатгалыг сайжруулах чиглэлээр илүү их арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Польш) | | | | |
| 167. | 116.97.Ядуурлыг бууруулах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхийн тулд нийгэм, эдийн засгийн хөгжлийг үргэлжлүүлэн дэмжих (БНХАУ) | | | | |
| 168. | 116.93.Нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай өрхүүдэд хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээгээ үргэлжлүүлэх (Мьянмар) | | | | |
| 169. | 116.90.Шүүх засаглал, төрийн албан дахь авлигатай тэмцэх, авлигатай холбоотой аливаа хэргийг мөрдөн шалгах хүч чармайлтаа эрчимжүүлэх (Люксембург) | -"Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан. | -Хэрэгжсэн. | Авлигатай тэмцэх газар. | |
| 170. | 116.91.Шүүх засаглал, төрийн албан дахь авлигатай тэмцэх хүч чармайлтаа эрчимжүүлэх (Тимор-Лесте) | | | | |

---o0o---